



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 442

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит зарим байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 57,182,253.00 (тавин долоон сая нэг зуун наян хоёр мянга хоёр зуун тавин гурав) төгрөгийн балансын үнэ, 44,682,253.00 (дөчин дөрвөн сая зургаан зуун наян хоёр мянга хоёр зуун тавин гурав) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг (зарим үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглах хугацааг сунган үнийг шинэчлэн тогтоож) хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хилийн боомтын захиргааны дарга Б.Батхишиг, "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133005911
23-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 09 дугаар сарын 1-ны өдрийн
118 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНУУДЫН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгө эзэмшигч төрийн өмчит байгууллага	Автомашины нэр, марк дугаар	Үйлдвэр- лэсэн он /Ашиглалтад орсон он	Хөрөнгийн балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага	Шинэчлэн тогтоосон үнэ	Цаашид ашиглах хугацаа
1	Засгийн газрын автобааз	Ландкрузер-200, 08-05 УБҮ, /арал № JTMHV09J9B5018860/	2011/2011	30,000,000.00	17,500,000.00	Хилийн боомтын захиргаа /Арц суурь боомт/		
2	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Хьюндай Соната NF6 01-40УБ3 /арал № КМНЕТ41АР9А535340/	2008/2008	27,182,253.00	27,182,253.00	Хилийн боомтын захиргаа /Боршоо боомт/	6,000,000.00	2
				57,182,253.00	44,682,253.00		6,000,000.00	
Нийт дүн				(тавин долоон сая нэг зуун наян хоёр мянга хоёр зуун тавин гурван төгрөг)	(дөчин дөрвөн сая зургаан зуун наян хоёр мянга хоёр зуун тавин гурван төгрөг)		(зургаан сая төгрөг)	